



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



JICA  
Japan International  
Cooperation Agency



ADB ASIAN  
DEVELOPMENT  
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

# СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

ОРОС ХЭЛ

УЛААНБААТАР 2021





БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



Japan International  
Cooperation Agency



ADB ASIAN  
DEVELOPMENT  
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН  
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ  
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

# ЗӨВЛӨМЖ

ОРОС ХЭЛ

*АНХНЫ ХЭВЛЭЛ*

УЛААНБААТАР 2021



## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

---

|                            |   |
|----------------------------|---|
| Суралцагчийн үнэлгээ ..... | 2 |
|----------------------------|---|

## СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

---

|   |    |
|---|----|
| Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж .....                                   | 5  |
| 1.1. Сургалтын үнэлгээний ерөнхий ойлголт .....   | 5  |
| 1.2. Гадаад хэлний үнэлгээний шалгуурыг<br>боловсруулсан арга зүй .....                         | 6  |
| 1.3. Орос хэлний бүлэг сэдэв / нэгж хичээлийн<br>үнэлгээний жишиг шалгуур .....                 | 9  |
| 1.4. Гадаад хэлний үнэлгээний шалгуурт суурилсан<br>даалгавар боловсруулах арга, аргачлал ..... | 21 |
| Хоёр: Нэгж үнэлгээний жишиг даалгавар .....   | 26 |
| 2.1. Суурь боловсролын 9-р ангийн жишиг даалгавар .....   | 26 |
| 2.2. Бүрэн дунд боловсрол 12-р ангийн жишиг даалгавар .....                                     | 31 |
| Гурав: Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал .....                                       | 36 |
| 3.1. Даалгаврын гүйцэтгэлийг нэгтгэн дүгнэх арга аргачлал .....                                 | 36 |
| Дөрөв. Нэр томъёоны тайлбар .....   | 42 |

## СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго<sup>1</sup>/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх<sup>2</sup>/, үнэлж дүгнэх<sup>3</sup> зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ **“шалгуур”**-г суурилсан байна.

### ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд **“үнэлгээ”**-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

<sup>1</sup> Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

<sup>2</sup> Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

<sup>3</sup> Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад<sup>4</sup> нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



<sup>4</sup> Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.






## Нэг. Үнэлгээний шалгуурыг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж

### 1.1. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Боловсролын чанарын асуудал нь үнэлгээтэй салшгүй холбоотой бөгөөд сургалтын үнэлгээний зорилго нь сурагчдын сурах хүсэл тэмүүллийг бадраан, сурах үйл ажиллагаанд нь идэвхжүүлж, суралцахуй, багшийн заах арга зүйг сайжруулахад оршино. Сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шинэчлэн сайжруулахад хэрэгцээтэй мэдээллийг тодорхойлох, олж авах, хангах үйл явцыг үнэлгээ гэнэ. /Source: Kemmis, 1989, p.117/.

*Суралцагчийн үнэлгээ* гэдэгт сурлагын амжилтын түвшинг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх тэдэнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явцыг ойлгоно. Суралцагчийн үнэлгээ нь тухайн сургалтын хөтөлбөрийн хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүнг тодорхойлсон “шалгуур”- т суурилсан байна.

*Шалгуурт суурилсан үнэлгээний* зорилт нь сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилтод үндэслэсэн байна. *Шалгуурт суурилсан үнэлгээ* нь суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчийн гүйцэтгэлтэй бус зөвхөн өөрийн өмнөх гүйцэтгэлтэй харьцуулж үнэлэн дүгнэх юм. Ерөнхий боловсролын сургуульд одоогоор шалгуурт суурилсан гурван төрлийн үнэлгээг ашиглаж байна.




Сурагчдын мэдлэг, чадвар, хандлагыг оношлох, явцын ба үр дүнгийн үнэлгээгээр үнэлнэ.

- Оношлох үнэлгээ (Diagnostic Assessment) нь сурах үйл ажиллагаанд тулгарч байгаа бэрхшээл, түүний шалтгааныг тодорхойлох зорилгоор хичээлийн жил, хагас жил, улирал, бүлэг сэдвийн эхэнд сурагчийн мэдлэг, чадвар, хандлагын түвшинг тандаж илрүүлэхэд чиглэнэ.
- Явцын үнэлгээ (Formative assessment) нь сурагчийн ахиц, хөгжлийн талаар мэдээлэл цуглуулах, суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл сургалтын явцад тогтмол хийгдэж, багш, сурагч, эцэг эхэд мэдээлэл өгөх, эргэх холбоо бий болгоход чиглэнэ.
- Үр дүнгийн үнэлгээ (Summative assessment) нь сурагчийн тухайн хичээлийн жил, хагас жил, бүлэг сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадварын түвшинг тогтоох, хандлага төлөвшилд үнэлэлт, дүгнэлт өгөхөд чиглэнэ. Анги дэвших болон төгсөх шалгалтаар сургалтын хөтөлбөрийн үнэлгээний зорилт, шалгуур, жинг үндэслэн үр дүнгийн үнэлгээ хийнэ.

## 1.2 ГАДААД ХЭЛНИЙ СУДЛАГДАХУУНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУРЫГ БОЛОВСРУУЛСАН АРГА ЗҮЙ

Аливаа гадаад хэлний сургалт нь сурагчдыг хэлэхүйн дөрвөн чадварт (сонсох, ярих, унших, бичих) сургах зорилго тавьдаг тул тэдгээрийг судлагдахууны үнэлгээний нэгжээр сонгон тодорхойлсон. Үнэлгээний нэгж нь нэгж хичээлээс ялгаатай. Үнэлгээний нэгж нь тухайн агуулгын хувьд сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг илрүүлэн дүгнэх шалгуурыг нэгтгэсэн нэгж бол, нэгж хичээл нь сургалтын хөтөлбөрийн агуулгыг томсгон, дидактик нэгжид хуваасан шийдэл бүхий агуулгын хуваарилалт юм.

Дараах схемээс суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурыг гаргасан дарааллыг харж болно.



✓ **Үнэлгээний нэгж**

Үнэлгээний нэгж гэдгийг тухайн ангийн агуулгын хувьд сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг илрүүлэн дүгнэх шалгуурын нэгтгэл гэж ойлгож болно.

Орос хэлний хичээлийн үнэлгээний нэгжийг сурагчийн орос хэлээр мэдээллийг хүлээн авах /сонсох, унших/, хүлээн авсан мэдээллээ боловсруулан бүтээлчээр илэрхийлэх /ярих, бичих/ чадварыг интеграцчилан *Сонсох – бичих, Сонсох – ярих, Унших –ярих, Унших – бичих* гэж тодорхойлсон.

✓ **Суралцахуйн үр дүн**

Суралцахуйн үр дүн гэдэг нь тухайн хичээл, хөтөлбөрийг судалсны эцэст сурагчид юу мэддэг, чаддаг болсон байхыг тодорхойлсон тусгай илэрхийлэл юм.

Орос хэл судлагдахууны үнэлгээний шалгуурыг боловсруулахдаа VII-XII анги тус бүрийн сургалтын хөтөлбөрийн агуулга болох суралцахуйн зорилтыг багцалж, хэлэхүйн үндсэн чадваруудын хослолд тулгуурлан суралцахуйн үр дүнг тодорхойлсон.

✓ **Үнэлгээний шалгуур**

Үнэлгээний шалгуур нь сурагчийн ажлыг хэмжих жишиг стандартын цогц бөгөөд сурагч суралцахуйн үр дүнд хүрсэн үү, үр дүнд хүрэхийн тулд юу хийж чаддаг болсон байх вэ? гэдгийг илэрхийлнэ.

Суралцахуйн үр дүнгээс үнэлгээний шалгуурыг боловсруулсан болно.

Үнэлгээний шалгуурт юуг, хэрхэн, яаж үнэлэхийг тусгасан байдаг ба хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй (*Sadler, 1987*). Үүнд:

1. Шалгуур - юу хийх ёстой вэ? гэдэг асуултад хариулна.
2. Гүйцэтгэлийн үзүүлэлт – яаж хийх ёстой вэ? асуултад хариулагдана.

Суралцахуйн үр дүн тус бүрээс үнэлгээний шалгуурыг гаргаж, шалгуур тус бүрийг 4 түвшнээр ангилан гүйцэтгэлийн хүрэх түвшинг боловсруулсан. Орос хэл судлагдахууны үнэлгээний шалгуурын тоон үзүүлэлтийг харуулбал:

Хүснэгт 1. Орос хэлний судлагдахууны үнэлгээний шалгуурын тоо

| Анги              | Суралцахуйн зорилтын тоо | Үнэлгээний нэгж бүрийн суралцахуйн үр дүнгийн тоо |             |            |             | Суралцахуйн үр дүнгээс гаргасан шалгуурын тоо /үнэлгээний нэгж бүрээр/ |             |            |             |
|-------------------|--------------------------|---|-------------|------------|-------------|--|-------------|------------|-------------|
|                   |                          | Сонсох-бичих                                      | Сонсох-ярих | Унших-ярих | Унших-бичих | Сонсох-бичих   | Сонсох-ярих | Унших-ярих | Унших-бичих |
| 7                 | 48                       | 1   | 3           | 3          | 2           | 2  | 3           | 4          | 3           |
| 8                 | 49                       | 1   | 2           | 3          | 3           | 1  | 3           | 5          | 4           |
| 9                 | 49                       | 1   | 2           | 2          | 1           | 1  | 2           | 3          | 3           |
| 10/заавал судлах  | 44                       | 1   | 1           | 2          | 2           | 1  | 4           | 5          | 4           |
| 11 /заавал судлах | 44                       | 1   | 1           | 2          | 2           | 1  | 1           | 4          | 3           |

|                    |            |          |           |           |           |          |           |           |           |
|--------------------|------------|----------|-----------|-----------|-----------|----------|-----------|-----------|-----------|
| 12 /заавал судлах  | 48         | 1        | 1         | 1         | 2         | 2        | 1         | 2         | 3         |
| 10 /сонгон судлах  | 33         | -        | 1         | 1         | 1         | -        | 1         | 1         | 2         |
| 11/сонгон судлах/  | 41         | -        | 2         | 2         | 1         | -        | 2         | 2         | 1         |
| 12 /сонгон судлах/ | 41         | -        | 2         | 2         | 2         | -        | 3         | 2         | 2         |
| <b>Нийт</b>        | <b>397</b> | <b>6</b> | <b>15</b> | <b>18</b> | <b>16</b> | <b>8</b> | <b>20</b> | <b>28</b> | <b>25</b> |

Нэгжийн суралцахуйн үр дүнгээс анги хоорондын болон тухайн ангийн агуулгын залгамж холбоо, өргөсөл, гүнзгийрэл тодорхой харагдана.

### Хүснэгт 2. Суурь боловсролын Унших-ярих нэгжийн үнэлгээний шалгуур

| Д/д | 7 анги  | 8 анги  | 9 анги  |
|-----|---|---|---|
| 1   | <ul style="list-style-type: none"> <li>– Сурагч зураг болон эд юмсыг <b>нэрлэж, түүнийг дүрслэн ярьж чаддаг</b> болно.</li> <li>– Мэдээллийн хэмжээ : 2-4 өгүүлбэр</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>– Сурагч судалсан сэдвийн хүрээнд уншсан эхийн агуулгыг <b>бүрэн гүйцэд ойлгосноо илэрхийлж чаддаг болно. /пересказ/</b></li> <li>– Мэдээллийн хэмжээ: 4-6 өгүүлбэр</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>– Сурагч судалсан сэдвийн хүрээнд уншсан эхийн агуулгыг ойлгон, түүний талаар <b>өөрийн бодол санаагаа илэрхийлж чаддаг болно.</b></li> <li>– Мэдээллийн хэмжээ: өгүүлбэр</li> </ul> |

### Хүснэгт 3. Бүрэн дунд боловсролын Сонсох-ярих нэгжийн үнэлгээний шалгуур

| Д/д | 10 анги  | 11 анги  | 12 анги  |
|-----|--|--|--|
| 1   | <ul style="list-style-type: none"> <li>– Сурагч судалсан сэдвийн хүрээнд богино эх сонсоод ойлгосноо илэрхийлж чаддаг болно.</li> </ul>  | <ul style="list-style-type: none"> <li>– Сурагч эхээс хэрэгцээт мэдээллийг түүвэрлэн сонсож чаддаг болно.</li> </ul>   | <ol style="list-style-type: none"> <li>1. Сурагч эхээс хэрэгцээт мэдээллийг түүвэрлэн сонсоод нэгтгэн дүгнэж чаддаг болно.</li> </ol>  |
| 2   | <ul style="list-style-type: none"> <li>– Сурагч судалсан сэдвийн хүрээнд үгсийн сан, хэлзүйн мэдлэгээ ашиглан харилцан яриа өрнүүлж чаддаг болно</li> <li>– Мэдээллийн хэмжээ: 10-12 асуулт хариулт бүхий <b>лавлаж асуусан, сэдэлжүүлсэн</b> харилцан яриа</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>– Сурагч сэдвийн хүрээнд хэлзүйн мэдлэгээ ашиглан мэдээлэл, санал солилцсон харилцан яриа өрнүүлж чаддаг болно.</li> <li>– Мэдээллийн хэмжээ:</li> <li>– 10-12 асуулт хариулт бүхий <b>мэдээлэл, санал солилцсон</b> харилцан яриа</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>– Сурагч сэдвийн хүрээнд авиазүй, хэлзүйн мэдлэгээ ашиглан өдөр тутам тохиолдох харилцааны нөхцөл байдлыг ойлгосноо илэрхийлж чаддаг болно.</li> <li>– Мэдээллийн хэмжээ:</li> <li>– 12-14 асуулт хариулт бүхий <b>үзэл бодлоо илэрхийлэх, мэтгэлцээн өрнүүлэх</b> харилцан яриа</li> </ul> |

Орос хэлний сургалтын хөтөлбөр дэх агуулга дараах бүлэг сэдвийн хүрээнд тодорхойлогдоно.

**Хүснэгт 4. Орос хэлний хичээлээр дунд ангид судлах сэдвийн хүрээ**

| д/д | Сэдвийн хүрээ             | VII анги | VIII анги | IX анги |
|-----|---------------------------|----------|-----------|---------|
| 1   | Знакомство. Семья         | ✓        | ✓         | ✓       |
| 2   | Повседневная жизнь        | ✓        | ✓         |         |
| 3   | Отдых и увлечение         |          |           | ✓       |
| 4   | Профессия и работа        |          |           | ✓       |
| 5   | Окружающая среда. Природа | ✓        | ✓         |         |
| 6   | Страна и люди             |          | ✓         | ✓       |

**Хүснэгт 5. Орос хэлний бүрэн дунд боловсролын судлах сэдвийн хүрээ**

| Сэдвийн хүрээ |                              |   |  |   |
|---------------|------------------------------|---|--|---|
| д/д           | Модулийн нэр                 | X анги  | XI анги  | XII анги  |
| 1             | Социально - бытовая сфера    | Семья, повседневная жизнь, увлечение, правила этикета.      | Семья, малая Родина, правила хорошего тона.                                  | Личностные ценности, хорошие манеры поведения и общения.                    |
| 2             | Социально - культурная сфера | Охрана природы, мегаполис, Страна и люди: русские писатели. | Охрана природы<br>Окружающая среда<br>Страна и люди: великие люди искусства. | Охрана природы<br>Страна и люди: традиции и обычаи, знаменитые люди России. |
| 3             | Учебно - трудовая сфера      | Личное развитие и самореализация, профессия.                | Выбор профессии, российские вузы, традиции и обычаи.                         | Образование, профессия и работа, этикет путешествий.                        |

Эдгээр сэдвийг спираль хэлбэрээр энгийнээс нарийн, хөнгөнөөс хүнд рүү чиглүүлэн судлахаар сургалтын хөтөлбөр, сурах бичигт тусгасан. Анги ахих бүрт судлах сэдвийн хүрээ өргөсөж, үгийн сан, хэлзүйн талаарх мэдлэг, чадвар, хэлэхүйн үндсэн чадвар нь гүнзгийрч байдаг.

## 1.3. ОРОС ХЭЛНИЙ БҮЛЭГ СЭДЭВ / НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖИШИГ ШАЛГУУР

### 1.3.1. IX АНГИЙН “СЕМЬЯ” БҮЛЭГ СЭДВИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Орос хэлний хичээлийн үнэлгээний шалгуурыг хэлэхүйн үндсэн чадваруудын хослолд тулгуурлан гаргасан талаар бид өмнөх хэсэгт танилцуулсан билээ. Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурыг гаргасан аргачлалыг IX ангийн “Семья” бүлэг сэдвийн жишээн дээр Хүснэгт 1 – 9-ийг харж болно.

## IX АНГИЙН “СЕМЬЯ” БҮЛЭГ СЭДВИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 1. IX ангийн “Семья” бүлэг сэдвийн үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнг тодорхойлсон аргачлал

| Суралцахуйн зорилт                                    | Үнэлгээний нэгж | Суралцахуйн үр дүн   |
|---|-----------------|--|
| 9.A1, 9.A2, 9.A3, 9.A4, 9.Г5.                         | Сонсох-ярих     | Сурагч орос хэлний авиа, үгийн өргөлт (подвижность ударения в словах <i>письмо-письма, мой-мои</i> ), өгүүлбэрийн аялгыг (ИК-1, ИК-2, ИК-5) ялган таньж, зөв дуудаж чаддаг болно.  |
|   |                 | Сурагч “Семья” сэдвийн хүрээнд харилцагчийнхаа санаа бодлыг сонсож ойлгоод, хэлзүйн мэдлэг, үгийн сангийн нөөцөө ашиглан хариу илэрхийлж чаддаг болно.   |
| 9.A4.Б, 9.П2, 9.П3.                                   | Сонсох-бичих    | Сурагч “Семья” сэдвийн хүрээнд сонссон богино эх, энгийн харилцан ярианаас хэрэгцээт мэдээллийг тэмдэглэн авч чаддаг болно.  |
| 9.Ч1, 9.Ч2, 9.Ч7, 9.Ч4, 9.Ч6, 9.Г7.                   | Унших-ярих      | Сурагч “Семья” сэдвийн хүрээнд уншсан эхийн агуулгыг ойлгон, түүний талаар өөрийн бодол санаагаа илэрхийлж чаддаг болно.   |
|   |                 | Сурагч “Семья” сэдвийн хүрээнд хэлзүйн мэдлэгээ ашиглан харилцан яриа өрнүүлж санаа бодлоо илэрхийлж чаддаг болно.   |
| 9.Ч3, 9.Ч5, 9.П1, 9.П2, 9.П4.                         | Унших-бичих     | Сурагч “Семья” сэдвийн хүрээнд үгийн сангийн нөөц, хэлзүйн мэдлэгээ ашиглан өгүүлбэр, дан (монолог) болон харилцан яриа (диалог) зохион бичиж, санаа бодлоо илэрхийлж чаддаг болно.  |
| 9.ВР1, 9.ВР2, 9.ВР14, 9.ВР16, 9.ВР22, 9.ВР23, 9.ВР24. | Хэлний мэдлэг   | Үгийн өргөлт (подвижность ударения в словах: <i>земля - земли</i> ), өгүүлбэрийн аялга (ИК-1, ИК-2, ИК-5), үйл үгийн чиглэл, хөдөлгөөн заасан үйл үг ( <i>ехать, ездить, ходить</i> ), дайвар үг (наречие на - о), энгийн нийлмэл өгүүлбэр ( <i>но</i> холбоос), УНӨ ( <i>чтобы</i> холбоостой тайлбар гишүүн өгүүлбэр) – ийг зөв хэрэглэж чаддаг болно. |

Хүснэгт 2. “СЕМЬЯ” бүлэг сэдвийн хүрээнд сонсох – ярих үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуурыг тодорхойлсон аргачлал

| Үнэлгээний нэгж | Суралцахуйн үр дүн  | Суралцахуйн үр дүнгийн шалгуур   |
|-----------------|---|--|
| Сонсох-ярих     | Сурагч орос хэлний авиа, үгийн өргөлт (подвижность ударения в словах <i>письмо-письма, мой-мои</i> ), өгүүлбэрийн аялгыг (ИК-1, ИК-2, ИК-5) ялган таньж, зөв дуудаж чаддаг болно. | Үг хэллэг, богино эхийг сонсоод өргөлтөт ба өргөлтөт бус үеийн эгшиг, гийгүүлэгч авиа, үгийн өргөлт, өгүүлбэрийн аялгыг ялган таньж зөв дуудан уншдаг.                                     |
|                 | Сурагч орос хэлний авиа, үгийн өргөлт (подвижность ударения в словах <i>письмо-письма, мой-мои</i> ), өгүүлбэрийн аялгыг (ИК-1, ИК-2, ИК-5) ялган таньж, зөв дуудаж чаддаг болно. | Харилцагчийнхаа ярианы өнгө, аялгаас түүний бодол санааг ойлгож, хариу үйлдэл хийдэг: ярилцагчийн асуултад хариулдаг, ойлгоогүй зүйлээ тодруулан асуудаг, өөрийн бодол санааг илэрхийлдэг. |

### Хүснэгт 3. “СЕМЬЯ” бүлэг сэдвийн жишээн дээр **сонсох** – **ярих** нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуурын гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур   | ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН  |   |   |   |
|--|--|---|---|---|
|  | I  | II  | III   | IV  |
| Үг хэллэг, богино эхийг сонсоод өргөлтөт ба өргөлтөт бус үеийн эгшиг, гийгүүлэгч авиа, үгийн өргөлт, өгүүлбэрийн аялгын төрлийг ялган таньж зөв дуудан уншдаг.                 | Үг хэллэг, богино эхийг сонсоод өргөлтөт ба өргөлтөт бус үеийн эгшиг, гийгүүлэгч авиа, үгийн өргөлт, өгүүлбэрийн аялгын төрлийг зарим нэг тохиолдолд зөв ялган таньж уншдаг. | Үг хэллэг, богино эхийг сонсоод үгийн өргөлтөт ба өргөлтөт бус үеийн эгшиг, гийгүүлэгч авиаг төрөлх хэлний авиатай хольж дууддаг. | Үг хэллэг, богино эхийг сонсоод үгийн өргөлт, өгүүлбэрийн аялгын төрлийг ... дийлэнх тохиолдолд зөв ялган таньж уншдаг.   | Үг хэллэг, богино эхийг сонсоод өргөлтөт ба өргөлтөт бус үеийн эгшиг, гийгүүлэгч авиа, үгийн өргөлт, өгүүлбэрийн аялгын төрлийг ялган таньж, алдаагүй зөв дуудан уншдаг.  |
| Харилцагчийнхаа ярианы өнгө, аялгаас түүний бодол санааг ойлгож, хариу үйлдэл хийдэг: асуултад хариулдаг, ойлгоогүй зүйлээ тодруулан асуудаг, өөрийн бодол санааг илэрхийлдэг. | Харилцагчийнхаа ярианы өнгө, аялгаас (ИК-1, ИК-2, ИК-3) түүний бодол санааг дутуу ойлгож, салангид үг, хэллэгээр асуултад хариулахыг оролддог.                               | Харилцагчийнхаа ярианы өнгө, аялгаас (ИК1, ИК-2, ИК-3) түүний бодол санааг дутуу ойлгож, асуултад энгийн өгүүлбэрээр хариулдаг.   | Харилцагчийнхаа ярианы өнгө, аялгаас (ИК-1, ИК-2, ИК-3) түүний бодол санааг ойлгож, хариу үйлдэл хийдэг: ярилцагчийн асуултад хариулдаг, загвар ашиглан асуулт тавьдаг, өөрийн бодол санааныхаа дийлэнхийг илэрхийлдэг. | Харилцагчийнхаа ярианы өнгө, аялгаас (ИК-1, ИК-2, ИК-3) түүний бодол санааг бүрэн ойлгож, хариу үйлдэл хийдэг: ярилцагчийн асуултад хариулдаг, ойлгоогүй зүйлээ тодруулан асуудаг, өөрийн бодол санааг үндэслэлтэйгээр илэрхийлдэг. |

### Хүснэгт 4. “СЕМЬЯ” бүлэг сэдвийн хүрээнд **сонсох** – **бичих** үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуурыг тодорхойлсон аргачлал

| Үнэлгээний нэгж | Суралцахуйн үр дүн  | Суралцахуйн үр дүнгийн шалгуур   |
|-----------------|---|--|
| Сонсох-бичих    | Сурагч “Семья” сэдвийн хүрээнд сонссон богино эх, энгийн харилцан ярианаас хэрэгцээт мэдээллийг тэмдэглэн авч чаддаг болно. | Богино эх, энгийн харилцан ярианы агуулга болон түүнд оролцогчдын санаа бодлыг сонсоод, сонирхсон мэдээллийг сонгон тэмдэглэдэг. |

**Хүснэгт 5. “СЕМЬЯ” бүлэг сэдвийн жишээн дээр сонсох – бичих нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуурын гүйцэтгэлийн түвшин**

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур  | ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН  |  |   |   |
|---|--|--|---|---|
|   | I  | II   | III   | IV  |
| Богино эх, энгийн харилцан ярианы агуулга болон түүнд оролцогчдын санаа бодлыг сонсоод, сонирхсон мэдээл-лээ түүвэрлэн тэмдэглэдэг. | Сонссон богино эх, энгийн харилцан ярианаас хэрэгцээт мэдээллийг зарим нэг тохиолдолд зөв тэмдэглэдэг. | Сонссон богино эх, энгийн харилцан ярианаас хэрэгцээт мэдээллийн цөөн хэсгийг зөв тэмдэглэдэг. | Богино эх, энгийн харилцан ярианы агуулга болон түүнд оролцогчдын санаа бодлыг сонсоод, хэрэгцээт мэдээллийн дийлэнхийг зөв сонгон тэмдэглэдэг. | Богино эх, энгийн харилцан ярианы агуулга болон түүнд оролцогчдын санаа бодлыг сонсоод, хэрэгцээт мэдээллийг бүрэн гүйцэд зөв сонгон тэмдэглэдэг (сонссон эхийн үзэл санааг батлах үг, хэллэг, өгүүлбэрийг олдог, харгалзуулдаг). |

**Хүснэгт 6. “СЕМЬЯ” бүлэг сэдвийн хүрээнд унших – ярих үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуурыг тодорхойлсон аргачлал**

| Үнэлгээний нэгж | Суралцахуйн үр дүн   | Суралцахуйн үр дүнгийн шалгуур   |
|-----------------|--|--|
| Унших-ярих      | Сурагч “Семья” сэдвийн хүрээнд (бүх дэд сэдэвт унших эх буй) уншсан эхийн агуулгыг ойлгон, түүний талаар өөрийн бодол санаагаа илэрхийлж чаддаг болно. | Уншсан зүйлийн талаар өөрийн бодол санааг илэрхийлэхдээ шинэ үг, хэллэгийн утгыг оновчтой сонгож хэрэглэдэг.<br>Ярих, унших төрөл бүрийн даалгавар биелүүлэн, уншсан эхийн агуулгыг ойлгосноо илэрхийлдэг. |
|                 | Сурагч “Семья” сэдвийн хүрээнд хэлзүйн мэдлэгээ ашиглан харилцан яриа өрнүүлж санаа бодлоо илэрхийлж чаддаг болно.                                     | Шинэ үг, хэллэг, хэлзүйн мэдлэгээ ашиглан хэл ярианы хэм хэмжээний (речевой этикет) дагуу харилцан яриа зохион ярьдаг.   |
|                 | Шинэ үг, хэллэг, хэлзүйн мэдлэгээ ашиглан хэл ярианы хэм хэмжээний (речевой этикет) дагуу харилцан яриа зохион ярьдаг.                                 | - Прочитайте диалог. Составьте аналогичный диалог, используя речевой этикет и изученный лексико-грамматический материал.   |



### Хүснэгт 7. “СЕМЬЯ” бүлэг сэдвийн жишээн дээр унших – ярих нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуурын гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур   | ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН   |  |  |  |
|--|---|--|--|--|
|  | I   | II   | III  | IV   |
| “Семья” сэдвийн хүрээнд уншсан зүйлийн талаар өөрийн бодол санааг илэрхийлэхдээ шинэ үг, хэллэгийн утгыг оновчтой сонгож хэрэглэдэг. | <ul style="list-style-type: none"> <li>Өөрийн бодол санааг <b>салангид үг, хэллэгээр</b> илэрхийлэхдээ шинэ үг, хэллэгийн утгыг <b>бусдын дэмжлэгтэйгээр</b> сонгож, хэрэглэхдээ <b>ихэнхдээ алдаа</b> гаргадаг.</li> <li>Уншсан эхийн шинэ үг, хэллэгийг <b>бусдын дэмжлэгтэйгээр</b> эх хэл рүү хөрвүүлдэг</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Өөрийн бодол санааг илэрхийлэхдээ шинэ үг, хэллэгийг цөөн тохиолдолд зөв хэрэглэдэг.</li> <li>Уншсан эхийн шинэ үг, хэллэгийн утгыг толь бичиг болон <b>бусдын дэмжлэгтэйгээр</b> эх хэл рүү хөрвүүлдэг.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Өөрийн бодол санааг илэрхийлэхдээ шинэ үг, хэллэгийн утгыг зөв сонгож, хэрэглэхдээ <b>цөөн</b> алдаа гаргадаг.</li> <li>Уншсан эхийн шинэ үг, хэллэгийг <b>толь бичиг ашиглан</b> эх хэл рүү хөрвүүлдэг.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Өөрийн бодол санааг илэрхийлэхдээ шинэ үг, хэллэгийн утгыг оновчтой сонгож <b>бүтээлчээр</b> хэрэглэдэг.</li> <li>Уншсан эхийн шинэ үг, хэллэгийн утгыг хам сэдвээс таамаглан <b>бие даан</b> эх хэл рүү хөрвүүлдэг.</li> </ul> |
| Ярих, унших төрөл бүрийн даалгавар биелүүлэн, уншсан эхийн агуулгыг ойлгосноо илэрхийлдэг.   | Уншсан эхийн агуулгыг <b>салангид үг, хэллэгээр</b> тодорхойлдог.   | <ul style="list-style-type: none"> <li>Уншсан эхийн агуулгын дагуу асуултын <b>цөөн тохиолдолд</b> зөв хариулдаг.</li> <li>Уншсан эхийн агуулгыг <b>дутуу өгүүлбэрээр</b> тодорхойлж, гарчиг өгөхийг оролддог.</li> </ul>                                  | <ul style="list-style-type: none"> <li>Уншсан эхийн агуулгын дагуу асуултын <b>дийлэнх хэсэгт</b> зөв хариулдаг.</li> <li>Уншсан эхийн агуулгыг логик холбоо бүхий <b>цөөн өгүүлбэрээр</b> тодорхойлж, эхэд гарчиг өгдөг.</li> </ul>                       | <ul style="list-style-type: none"> <li>Уншсан эхийн агуулгын дагуу асуултад <b>бүрэн гүйцэд</b> хариулдаг.</li> <li>Агуулгыг логик холбоо бүхий <b>хэд хэдэн өгүүлбэрээр</b> тодорхойлж, эхэд оновчтой гарчиг өгдөг.</li> </ul>  |
| Шинэ үг, хэллэг, хэлзүйн мэдлэгээ ашиглан хэл ярианы хэм хэмжээний (речево́й этикет) дагуу харилцан яриа зохион ярьдаг.              | <b>Загварын дагуу цөөн асуулт</b> , хариулт бүхий харилцан яриа зохион ярилцахыг хичээдэг.  | <b>Загварын дагуу</b> хэл ярианы хэм хэмжээг баримтлан <b>цөөн асуулт</b> , хариулт бүхий харилцан яриа зохион ярьдаг.   | <b>Загварын дагуу</b> хэлзүйн мэдлэг, шинэ үг, хэллэгийг хэрэглэж, өгүүлбэрийн аялга, хэл ярианы хэм хэмжээний дагуу <b>олон асуулт, хариулт</b> бүхий харилцан яриа зохиодог.   | <b>Бие даан</b> хэлзүйн мэдлэг, шинэ үг, хэллэгийг оновчтой зөв хэрэглэж, өгүүлбэрийн аялга, хэл ярианы хэм хэмжээний дагуу <b>олон асуулт, хариулт</b> бүхий харилцан яриа зохион ярьдаг.   |

**Хүснэгт 8. “СЕМЬЯ” бүлэг сэдвийн хүрээнд унших – бичих үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуурыг тодорхойлсон аргачлал**

| Үнэлгээний нэгж | Суралцахуйн үр дүн  | Суралцахуйн үр дүнгийн шалгуур  |
|-----------------|---|---|
| Унших-бичих     | Сурагч “Семья” сэдвийн хүрээнд үгийн сангийн нөөц, хэлзүйн мэдлэгээ ашиглан өгүүлбэр, дан (монолог) болон харилцан яриа (диалог) зохион бичиж, санаа бодлоо илэрхийлж чаддаг болно. | Хэлзүйн мэдлэгээ ашиглан энгийн болон нийлмэл өгүүлбэр зохиох ба хөрвүүлдэг (трансформация предложений) бичдэг. |
|                 |   | Үзүүлэн таниулах материал, ярианы загвар ашиглан харилцан яриа зохиодог ба хөрвүүлдэг (трансформировать).       |
|                 |   | Уншсан эх болон өөрийн мэдлэг, туршлагад тулгуурлан бодол санаагаа цөөн өгүүлбэрээр илэрхийлдэг.                |

**Хүснэгт 9. “СЕМЬЯ” бүлэг сэдвийн жишээн дээр унших – бичих нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуурын гүйцэтгэлийн түвшин**

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур   | ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН  |  |   |   |
|--|--|--|---|---|
|  | I  | II   | III   | IV  |
| “Семья” сэдвийн хүрээнд хэлзүйн мэдлэгээ ашиглан энгийн болон нийлмэл өгүүлбэр зохиох ба хөрвүүлдэг (трансформация предложений). | Энгийн өгүүлбэрийг нийлмэл өгүүлбэр болгон хөрвүүлэхийг оролддог боловч холбоос болон холбоос үгийг зөвхөн бусдын дэмжлэгтэйгээр зөв хэрэглэдэг. | <ul style="list-style-type: none"> <li>Хэлзүйн мэдлэгээ ашиглан энгийн болон нийлмэл өгүүлбэр зохиохдоо цөөн тохиолдолд үгээ зөв сонгож, зөв бичгийн дүрэм баримтлан бичдэг.</li> <li>Энгийн өгүүлбэрийг ЗНӨ болгон хөрвүүлэхдээ цөөн тохиолдолд холбоос үгийн утгыг зөв ойлгож хэрэглэдэг.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Хэлзүйн мэдлэгээ ашиглан энгийн болон нийлмэл өгүүлбэр зохиохдоо дийлэнх тохиолдолд үгийн утгыг зөв сонгож, зөв бичгийн дүрэм баримтлан бичдэг.</li> <li>Энгийн өгүүлбэрийг ЗНӨ, УНӨ болгон хөрвүүлэхдээ дийлэнх тохиолдолд холбоос болон холбоос үгийг зөв хэрэглэдэг.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Хэлзүйн мэдлэгээ ашиглан энгийн болон нийлмэл өгүүлбэр (ЗНӨ, УНӨ) зохиохдоо холбоос ба холбоос үгсийг зөв хэрэглэдэг.</li> <li>Өгүүлбэрийн утгыг алдагдуулахгүйгээр энгийн өгүүлбэрийг холбоос болон холбоос үг ашиглан ЗНӨ, УНӨ болгон зөв хөрвүүлэн бичдэг.</li> </ul> |

|   |  |  |   |   |
|---|--|--|---|---|
| <p>“Семья” сэдвийн хүрээнд” үзүүлэн таниулах материал, ярианы загвар ашиглан харилцан яриа зохиодог ба хөрвүүлдэг (трансформировать).</p> | <ul style="list-style-type: none"> <li>• Ярианы загвар ашиглан харилцан яриа зохиохыг оролддог.</li> <li>• Харилцан яриаг дан ярианд хөрвүүлэхдээ бусдын дэмжлэгийг авдаг.</li> </ul>  | <ul style="list-style-type: none"> <li>• Ярианы загвар болон асуулт ашиглан өөрийн санаа бодлыг бага зэрэг илэрхийлсэн харилцан яриа зохиодог.</li> <li>• Цөөн тохиолдолд харилцан ярианы утгыг ойлгон дан ярианд хөрвүүлдэг.</li> </ul>   | <ul style="list-style-type: none"> <li>• Зураг, ярианы загвар болон асуулт ашиглан өөрийн санаа бодлыг илэрхийлсэн харилцан яриа зөв зохиодог.</li> <li>• Харилцан яриаг дийлэнх тохиолдолд дан ярианд зөв хөрвүүлдэг.</li> </ul>   | <ul style="list-style-type: none"> <li>• Үзүүлэн таниулах материал, ярианы загвар болон төрөл бүрийн дасгал даалгавар ашиглан өөрийн санааг илэрхийлсэн харилцан яриа зохиодог.</li> <li>• Харилцан ярианы утгыг гүйцэд ойлгон дан ярианд зөв хөрвүүлдэг.</li> </ul>  |
| <p>“Семья” сэдвийн хүрээнд уншсан эх болон өөрийн мэдлэг, туршлагад тулгуурлан бодол санаагаа цөөн өгүүлбэрээр илэрхийлдэг.</p>           | <p>Эх зохиохдоо:</p> <ul style="list-style-type: none"> <li>• зорилго, сэдэвтэй холбоотой санааг салангид үг, хэллэг, цөөн тооны өгүүлбэрээр илэрхийлэхийг оролддог;</li> <li>• бодол санаагаа бусдын дэмжлэгтэйгээр логик холбоотой илэрхийлдэг;</li> <li>• үг, хэллэгийг хязгаарлагдмал хүрээнд зөв сонгож, бусдын дэмжлэгтэйгээр зөв бичгийн дүрэм баримтлан бичдэг.</li> </ul> | <p>Эх зохиохдоо:</p> <ul style="list-style-type: none"> <li>• зорилгоо дундаж хангаж, бодол санаагаа илэрхийлэх логик холбоо үе үе алдагддаг;</li> <li>• Зарим тохиолдолд эмх цэгцтэй цөөн өгүүлбэрээр санаагаа илэрхийлдэг;</li> <li>• үг, хэллэгийг хязгаарлагдмал хүрээнд ашигладаг: нэг хэвийн үг, хэллэгийг олон дахин давтан хэрэглэдэг;</li> <li>• цөөн тохиолдолд зөв бичгийн дүрэм баримтлан бичдэг.</li> </ul> | <p>Эх зохиохдоо:</p> <ul style="list-style-type: none"> <li>• зорилгоо харьцангуй гүйцэд хангаж, агуулга, сэдвийн холбоог ерөнхийд нь зөв гарган бичдэг;</li> <li>• дийлэнхдээ гол санаагаа логик дараалал сайтай илэрхийлдэг;</li> <li>• агуулга, сэдэвтээ тохируулан үгийн сангийн нөөцөөс судалсан шинэ үг, хэллэгийн дийлэнхийг ашигладаг;</li> <li>• дийлэнх тохиолдолд зөв бичгийн дүрэм баримтлан бичдэг.</li> </ul> | <p>Эх зохиохдоо:</p> <ul style="list-style-type: none"> <li>• зорилгоо ойлгож, агуулга, сэдвийн холбоог сайн гаргаж, санаагаа бүрэн гүйцэд илэрхийлдэг;</li> <li>• бодол санаагаа эмх цэгцтэй, логик холбоотой, найруулга сайтай илэрхийлдэг;</li> <li>• үгийн сангийн нөөцөө бүтээлчээр ашиглаж, агуулга, сэдэвтэйгээ бүрэн нийцүүлж, оновчтой зөв хэрэглэдэг;</li> <li>• Зөв бичгийн дүрэм баримтлан бичдэг.</li> </ul> |

**XII АНГИЙН “В МИРЕ ПРОФЕССИЙ”, “ВСЕ РАБОТЫ ХОРОШИ”  
НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

**1.3.2. XII АНГИЙН “В МИРЕ ПРОФЕССИЙ”, “ВСЕ РАБОТЫ ХОРОШИ”  
НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР**

Суралцахуйн үр дүнгийн шалгуурыг гаргасан аргачлалыг XII ангийн “В мире профессий”, “Все работы хороши” нэгж хичээлийн жишээн дээр Хүснэгт 1 – 9-ийг харж болно.

**XII АНГИЙН “В МИРЕ ПРОФЕССИЙ”, “ВСЕ РАБОТЫ ХОРОШИ”  
НЭГЖ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ**

**Хүснэгт 1. XII ангийн “В мире профессий”, “Все работы хороши” нэгж хичээлийн суралцахуйн үр дүнг тодорхойлсон аргачлал**

| Суралцахуйн зорилт  | Үнэлгээний нэгж | Суралцахуйн үр дүн   |
|---|-----------------|--|
| 12.А2, 12.А4, 12.Г2, 12.Г3, 12.Г4, 12.Г7, 12.ВР1 – 12.ВР25. | Сонсох-ярих     | Сурагч “В мире профессий”, “Все работы хороши” нэгж хичээлийн хүрээнд авиазүй, хэлзүйн мэдлэгээ ашиглан өдөр тутам тохиолдох харилцааны нөхцөл байдлыг ойлгосноо илэрхийлж чаддаг болно. |
| 12.А5, 12А,Б, 12П1.   | Сонсох-бичих    | Сурагч эхээс хэрэгцээт мэдээллийг түүвэрлэн сонсоод нэгтгэн дүгнэж чаддаг болно.   |
| 12.Ч4, 12.Ч6, 12.Ч1, 9.Ч4, 12.Г5, 12.Г6.                    | Унших-ярих      | Сурагч “В мире профессий”, “Все работы хороши” нэгж хичээлийн хүрээнд төрөл бүрийн мэдээллийг нарийвчлан судалж, хэлзүйн мэдлэгээ ашиглан нэгтгэн дүгнэн ярьж чаддаг болно.              |
| 12.Ч7, 12.Ч5, 12.П1, 12.П2, 12.П3, 12.П4, 12.ВР5 – 12.ВР25. | Унших-бичих     | Сурагч судалсан сэдвийн хүрээнд албан бичиг баримт бөглөн бичиж чаддаг болно.  |
|   |                 | Сурагч судалсан сэдвийн хүрээнд үгийн сангийн нөөц, хэлзүйн мэдлэгээ ашиглан эх болон харилцан яриа зохион бичиж чаддаг болно.   |
| 12.ВР4, 12.ВР14, 12.ВР20, 12.ВР21                           | Хэлний мэдлэг   | Интонация (ИК-1 – ИК-5), управление глагола, вводные слова, прямая и косвенная речь, простые и сложные предложения – г зөв хэрэглэж чаддаг болно.  |

**Хүснэгт 2. XII ангийн “В мире профессий”, “Все работы хороши” нэгж хичээлийн сонсох – ярих үнэлгээний нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуурыг тодорхойлсон аргачлал**

| Үнэлгээний нэгж | Суралцахуйн үр дүн   | Суралцахуйн үр дүнгийн шалгуур  |
|-----------------|--|---|
| Сонсох-ярих     | Сурагч “В мире профессий”, “Все работы хороши” нэгж хичээлийн хүрээнд авиазүй, хэлзүйн мэдлэгээ ашиглан өдөр тутам тохиолдох харилцааны нөхцөл байдлыг ойлгосноо илэрхийлж чаддаг болно. | Үгийн сангийн нөөц, хэлзүйн мэдлэгээ ашиглан хэл ярианы хэм хэмжээний (речевой этикет) дагуу албан ба албан бус яриа өрнүүлдэг (яриа өдөөх, асуух, хариулах). |

**Хүснэгт 3. XII ангийн “В мире профессий”, “Все работы хороши” нэгж хичээлийн сонсох – ярих нэгжийн суралцахуйн үр дүнгийн шалгуурын гүйцэтгэлийн түвшин**

| СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР  | ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН  |  |   |  |
|---|--|--|---|--|
- Какие основные обязанности вы выполняете?
- Моя главная обязанность: следить за здоровьем людей.
- Насколько ваша профессия полезна и важна для страны, общества?
- Без медицины просто никуда.

Это интервью . . . .

А. с диетологом                      В. с врачом                      С. с биологом                      D. с учителем

**Задание.** Прослушайте реплики диалога. Дайте ответные реплики. (задгай)

4. – Как вы думаете, работа должна приносить удовольствие или только деньги?  
– ...
5. – Где можно зарабатывать и получать удовольствие от работы?  
– ...
6. – Какая работа вам будет по душе?  
– ...
7. – Где вы мечтаете работать?  
– ...
8. – Трудно ли найти работу в нашей стране сейчас? Почему?  
– ...

### 2.2.2 ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ: СОНСОХ-БИЧИХ

|   |                        |   |
|---|------------------------|---|
| 1 | Сэдэв                  | Модуль III Учебно-трудовая сфера<br>“В мире профессии”, “Все работы хороши” нэгж хичээл   |
| 2 | Суралцахуйн зорилт     | 12.A1, 12.A2, 12.A5, 12.П3, 12.П4.  |
| 3 | Үнэлгээний нэгж        | Сонсох-бичих  |
| 4 | Суралцахуйн үр дүн:    | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагч эхээс хэрэгцээт мэдээллийг түүвэрлэн сонсоод нэгтгэн дүгнэж чаддаг болно.</li> </ul>  |
| 5 | Үнэлгээний шалгуур     | <ul style="list-style-type: none"> <li>• Сонссон өгүүлбэр, богино эхийг утгын түвшинд ойлгож, хэрэгцээт мэдээллийг сонгон авч нэгтгэн дүгнэдэг.</li> <li>• Сонссон богино эх, энгийн харилцан ярианы агуулгыг товчхон илэрхийлж санал бодлоо нэмэрлэдэг.</li> </ul> |
| 6 | Даалгаврын хэлбэр:     | Сонгох ба задгай даалгавар  |
| 7 | Даалгаврын тавил       | <ul style="list-style-type: none"> <li>• Прослушайте интервью два раза. Отметьте, какие высказывания являются ложными, а какие нет.</li> <li>• Прослушайте. Перескажите диалог в форме монолога.</li> </ul>   |
| 8 | Даалгаврын оноожуулалт | Тайлбар: сонгох даалгаврын хариулт бүрт 1 оноо өгөх, задгай даалгаврын хариултын хүнд хөнгөнөөс шалтгаалж 2-5 оноо өгөх   |

#### Жишиг даалгавар

**Задание.** Прослушайте интервью два раза. Отметьте, какие высказывания являются ложными, а какие нет. (сонгох)

#### Текст для аудирования

- Журналист: – Расскажите о себе: кем Вы работаете? Где Вы работаете?  
Сэргэлэн: – Меня зовут Сэргэлэн. Я работаю секретарём-референтом в строительной компании.  
Журналист: – Интересная работа. А почему Вы выбрали такую профессию?  
Сэргэлэн: – Я очень люблю свою профессию, потому что я люблю общаться с людьми, вести документацию различного рода.  
Журналист: – Какое образование нужно получить? Какими навыками должен обладать секретарь-референт?  
Сэргэлэн: – Желательно иметь высшее образование, знать английский язык, уметь работать на

компьютере, вести документацию и, конечно, исполнительность и вежливое обращение с людьми.

Журналист: – Спасибо. У Вас действительно интересная профессия. Желаю удачи Вам!

- |   |    |     |
|---|----|-----|
| 1. Сэргэлэн работает секретарём-референтом.             | Да | Нет |
| 2. Сэргэлэн не нравится её работа.                      | Да | Нет |
| 3. Секретарь-референт должен уметь вести документацию.  | Да | Нет |
| 4. Секретарю-референту нужны знания иностранного языка. | Да | Нет |
| 5. Секретарю-референту не нужно общаться с людьми.      | Да | Нет |

**Задание.** Прослушайте. Перескажите диалог в форме монолога. (задгай)

Текст для аудирования

- Стёпа, кем ты хотел стать в детстве?
- Когда я был маленьким, я хотел стать врачом, потом – юристом, потом – экономистом. А сейчас я работаю инженером, как мой отец. А кем хотела стать ты, Таня?
- О, у меня интересная история. Когда я родилась, моя мама сказала, что я буду музыкантом, как она. А папа хотел, чтобы Таня стала инженером, как он. Дедушка советовал мне стать врачом, а баушка говорила, что я должна стать журналистом.
- Интересно, что ты выбрала?
- А мне было интересно лечить животных. Я поступила на ветеринарный факультет, закончила его и стала ветеринаром.
- Можно сказать, что ты счастливый человек.
- Да, я счастливый человек, занимаюсь любимым делом.
- Я тоже люблю свою работу.

Пересказ диалога в письменной форме: *В детстве Стёпа хотел стать и врачом, и юристом, и экономистом. Но, когда вырос, стал инженером, как его отец. А родители, дедушка и бабушка Тани хотели, чтобы Таня стала музыкантом, инженером, врачом, журналистом. Но Таня любила лечить животных. Таня стала ветеринаром. Но в жизни Таня стала ветеринаром, а Стёпа - инженером. Они занимаются любимыми делами.*

### 2.2.3 ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ: УНШИХ-ЯРИХ

|   |                        |  |
|---|------------------------|--|
| 1 | Сэдэв                  | Модуль III Учебно-трудовая сфера<br>“В мире профессии”, “Все работы хороши” нэгж хичээл  |
| 2 | Суралцахуйн зорилт     | 12.Ч1, 12.Ч2, 12.Ч3, 12.Ч4, 12.Ч6, 12.Г1, 12.Г5, 12.Г6.  |
| 3 | Үнэлгээний нэгж        | унших-ярих   |
| 4 | Суралцахуйн үр дүн:    | <ul style="list-style-type: none"> <li>• Сурагч судалсан сэдвийн хүрээнд төрөл бүрийн мэдээллийг нарийвчлан судалж, хэлзүйн мэдлэгээ ашиглан нэгтгэн дүгнэн ярьж чаддаг болно.</li> </ul>  |
| 5 | Үнэлгээний шалгууур    | <ul style="list-style-type: none"> <li>• Эхийг нарийвчлан судалж унших (салангид мэдээллүүдийг нэгтгэн дүгнэх, харьцуулан жиших г.м.) замаар хэрэгцээт мэдээллийг олж авдаг.</li> <li>• Мэдээлэл бэлтгэхдээ судалсан шинэ үг, хэллэгийн утгыг ялган таньж, үгийн сангийн нөөц, хэлзүйн мэдлэгээ бүтээлчээр алдаагүй зөв хэрэглэдэг.</li> </ul> |
| 6 | Даалгаврын хэлбэр:     | Сонгох ба задгай даалгавар   |
| 7 | Даалгаврын тавил       | <ul style="list-style-type: none"> <li>• Выберите соответствующее выражение.</li> <li>• Как вы думаете, люди каких профессий нужны для развития вашего города (аймака, сомона)?</li> </ul>   |
| 8 | Даалгаврын оноожуулалт | <u>Тайлбар:</u> сонгох даалгаврын хариулт бүрт 1 оноо өгөх, задгай даалгаврын хариултын хүнд хөнгөнөөс шалтгаалж 2-5 оноо өгөх   |

**Жишиг даалгавар****Задание.** Выберите соответствующее выражение.

(сонгох)

- Зачем ты идёшь в школу?
  - Чтобы купить мясо.
  - Чтобы играть.
  - Чтобы учиться.
  - Чтобы смотреть фильм.
- Приглашаю тебя на литературный вечер! Это особенно интересно для тех, кто хочет стать писателем.
  - Привет, куда вы идёте?
  - Извините, у Вас есть лишний билет?
  - Спасибо, с удовольствием приду.
  - Спасибо за вкусный кофе.

**Задание.** Составьте рассказ по ситуации. Используйте прочитанный текст.

(задгай)

*Ситуация:* Вы рассказываете друзьям о Вашем родном городе (аймаке, сомоне).

- где Вы живёте (в каком городе, аймаке, сомоне),
- какой у вас город (аймак, сомон),
- люди каких профессий нужны для развития вашего города (аймака, сомона).

**2.2.4 ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ: УНШИХ-БИЧИХ**

|   |                        |  |
|---|------------------------|--|
| 1 | Сэдэв                  | Модуль III Учебно-трудовая сфера<br>“В мире профессии”, “Все работы хороши” нэгж хичээл  |
| 2 | Суралцахуйн зорилт     | 12.Ч1, 12.Ч7, 12.П1, 12.П2, 12.П3, 12.П4.  |
| 3 | Үнэлгээний нэгж        | унших-бичих  |
| 4 | Суралцахуйн үр дүн:    | <ul style="list-style-type: none"> <li>Сурагч судалсан сэдвийн хүрээнд албан бичиг баримт бөглөн бичиж чаддаг болно.</li> <li>Сурагч судалсан сэдвийн хүрээнд үгийн сангийн нөөц, хэлзүйн мэдлэгээ ашиглан эх болон харилцан яриа зохион бичиж чаддаг болно.</li> </ul>  |
| 5 | Үнэлгээний шалгууур    | <ul style="list-style-type: none"> <li>Төрөл бүрийн асуулга (анкет), бүртгэлийн хуудас гэх зэрэг албан бичиг баримт бөглөж чаддаг.</li> <li>Эх болон харилцан яриа зохион бичихдээ уншсан эх болон өөрийн мэдлэг, туршлагад тулгуурлан бодол санаагаа илэрхийлдэг.</li> <li>Эх зохион бичихдээ үгийн сангийн нөөц, хэлзүйн мэдлэгээ бүтээлчээр ашигладаг.</li> </ul> |
| 6 | Даалгаврын хэлбэр:     | Сонгох ба задгай даалгавар   |
| 7 | Даалгаврын тавил       | <ul style="list-style-type: none"> <li>Восстановите диалог, используя данные слова и выражения.</li> <li>Заполните анкету.</li> <li>Напишүите сочинение на тему “Труд красит человека”.</li> </ul>   |
| 8 | Даалгаврын оноожуулалт | <u>Тайлбар:</u> сонгох даалгаврын хариулт бүрт 1 оноо өгөх, задгай даалгаврын хариултын хүнд хөнгөнөөс шалтгаалж 2-5 оноо өгөх   |

**Жишиг даалгавар****Задание.** Восстановите диалог, используя данные слова и выражения.

(сонгох)

- Привет, Даша!
- .. 1 .. , Витя! Куда ты идёшь?
- Я иду на кружок.
- На .. 2 .. кружок?
- Я занимаюсь на кружке “Юный биолог”.
- Ты хочешь стать .. 3 .. ?
- Нет, я люблю лечить животных. Я хочу стать .. 4 .. .
- Да, это очень интересная .. 5 .. .

- |                |                |                |
|----------------|----------------|----------------|
| 1. А. Пока     | В. Здравствуй  | С. До свидания |
| 2. А. какое    | В. какая       | С. какой       |
| 3. А. биологом | В. биология    | С. врачом      |
| 4. А. врач     | В. ветеринаром | С. инженером   |
| 5. А. работа   | В. занятие     | С. труд        |

**Задание.** Заполните анкету.

(задгай)

*Фамилия, имя, отчество . . .*

- Дата рождения, место рождения . . .
- Национальность . . . гражданство . . .
- Контактная информация: а) мобильный телефон . . . , б) E-mail . . .
- Домашний адрес . . .
- Сведения о родителях (фамилия, имя, место работы, профессия, должность) . . .

## Гурав. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал

### 3.1 ДААЛГАВРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ НЭГТГЭН ДҮГНЭХ АРГА, АРГАЧЛАЛ

Сурагчид тухайн хичээл, бүлэг сэдвээр юу ойлгож мэдсэнийг харуулах нотолгоо янз бүр байж болно. Тухайлбал, гадаад хэлний хичээлээр сурагчдын хийсэн дасгал даалгавар, зохион бичлэг, гүйцэтгэсэн мэдлэг, чадвар шалгах тест, бие даалтын ажил (*Аман сэтгүүл*, хичээлээс гадуур уншлага, сурагчдын бүтээл, олимпиад, хичээлтэй холбоотой уралдаант ажлууд) – с гадна төрөл бүрийн программ хангамж, техник хэрэгсэл ашиглан нотолгоо бүрдүүлэх боломжтой.

Тухайлбал, “СЕМЬЯ” сэдвийн үр дүнгийн үнэлгээний нотолгоо болгож:

1. бүлэг сэдвийн шалгалтын гүйцэтгэл,
2. сурагчдын уншсан эх, өөрийн туршлагад тулгуурлан бичсэн зохион бичлэг,
3. сурагчдын тухайн бүлэг сэдвийн дагуу хийсэн бие даалтын ажлын нэг хэлбэр болох *Аман сэтгүүлийг* сонгон авч, тэдгээрийн гүйцэтгэлд анализ хийх аргачлалыг харуулав.

Нэгж / бүлэг сэдвийн үр дүнгийн үнэлгээг хийхдээ дараах зүйлийг анхаарна. Үүнд:

- үнэлгээний хэлбэрт тохирсон дүгнэх аргачлалыг сурагчдад нээлттэй танилцуулах,
- үнэлгээний шалгуурыг илрүүлэхүйц үнэлгээний жишиг даалгаврыг боловсруулах,
- үр дүнгийн үнэлгээний шалгалтыг гүйцэтгэсэн байдалд анализ хийн мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшинг тогтоох (анги нийтээр, сурагч тус бүрээр, жишиг даалгавар тус бүрээр г.м.), дүгнэлт гаргах,
- шинжилгээний дүгнэлтэд үндэслэн багш цаашдын ажлаа төлөвлөж, арга зүйгээ тодорхойлно.



## 1. “СЕМЬЯ” бүлэг сэдвийн үр дүнгийн үнэлгээнд шинжилгээ хийх аргачлал

| Эзэмших мэдлэг, ойлголт, чадвар       |   |  | Сурагчдын нэрс |          |          |     | даалгаврыг гүйцэтгэж чадсан сурагчдын тоо | даалгаврыг гүйцэтгэж чадаагүй сурагчдын тоо |
|---------------------------------------|---|--|----------------|----------|----------|-----|---|---|
|                                       |   |  | Сурагч 1       | Сурагч 2 | Сурагч 3 | ... |   |   |
|                                       |   |  | хувилбар       |          |          |     |   |   |
|                                       |   |  | A              | B        | C        | D   |   |   |
| Лексика.<br>Грамматика<br>(20 баллов) | 1 | Склонение существительных                      | +              |          |          |     | 3   | 12  |
|                                       | 2 | Спряжение глагола                              | +              |          |          |     |   |   |
|                                       | 3 | Лексика  | +              |          |          |     |   |   |
|                                       | 4 | Предлоги                                       | +              |          |          |     |   |   |
|                                       | 5 | Наречие  | -              |          |          |     |   |   |
|                                       | 6 | ССП (а, но)                                    | +              |          |          |     |   |   |
| Аудирование<br>(5 баллов)             | 1 | Аудирование: прослушивание, выполнение заданий | 5              |          |          |     |   |   |
| Говорение<br>(5 баллов)               | 2 | Говорение: Выбор соответствующих выражений     | 4              |          |          |     |   |   |
| Чтение (5 б)                          | 3 | Чтение: работа над текстом                     | 5              |          |          |     |   |   |
| Письмо<br>(10 баллов)                 | 4 | Письменное составление рассказа о семье        | 5              |          |          |     |   |   |
| Нийт авах оноо                        |   |  | 45             |          |          |     |   |   |
| Авсан оноо                            |   |  | 43             |          |          |     |   |   |
| Гүйцэтгэл                             |   |  | 95%            |          |          |     |   |   |

Дээрх бүлэг сэдвийн үр дүнгийн үнэлгээний шалгалтын гүйцэтгэлд гурван янзаар шинжилгээ хийж болно. Тухайлбал. Анги нийтээр нь, сурагч тус бүрээр, шалгалтын даалгавар тус бүрээр г.м.

Анги нийтээр нь шинжилгээ хийхдээ: 15 сурагч шалгагдсанаас ... сурагч – 100%, ... сурагч 95 %, ... сурагч 85% амжилттай гэх зэргээр ангийн сурагчдын амжилт ... %, АВ - ... % - ийг анги нийтээр нь хийж дүгнэлт гаргаж болно.

Сурагч тус бүрээр нь шинжилгээ хийхдээ: тухайн сурагч ямар даалгаврыг сайн гүйцэтгэж, ямар даалгаврыг хийж чадаагүйгээр нь суралцахуйн ямар зорилт биелэж буй эсэхийг тодорхойлж болно.

Сурагчдын ажилласан шалгалтын даалгавруудад шинжилгээ хийж дүгнэлт гаргаж болно. Тухайлбал, 1-р асуулт буюу нэр үгийг тийн ялгалаар хувиргах даалгаврыг сурагчид 100 % гүйцэтгэсэн тул энэ дүрмийг сайн ойлгосон, 4-р асуулт буюу энгийн нийлмэл өгүүлбэр зохиох даалгавар дээр 15 сурагчаас 7 сурагч алдаа гаргасан болон өгүүлбэр зохиож чадаагүй, энэ даалгавар хүндэдсэн байж болох, энэ дүрмийг дахин тайлбарлан ойлгуулах шаардлагатай, бичих даалгавар (письмо)-ыг үнэлэхдээ сурагчдын алдаа гаргасан дүрмийг давтах, дахин тайлбарлах, дасгал ажиллах гэх зэргээр даалгавар тус бүр дээр дүгнэлт гаргаж, цаашдын хичээлийн төлөвлөлтдөө юуг анхаарч ажиллахаа багш төлөвлөнө. Тухайлбал:

- хамгийн олон сурагч алдаа гаргасан даалгавар буюу дүрмийг тодруулж, түүнийг хэрхэн ажиллаж дутагдлыг арилгахаа төлөвлөх,
- зөв бичих чадвар төлөвшүүлэх арга, хэлбэрээ бодож боловсруулах,
- алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх дасгал даалгавар боловсруулах г.м.

Сурагчдын бичсэн зохион бичлэгт анализ хийхдээ дараах зүйлийг анхаарна. Үүнд:

- тухайн зохион бичлэгт тавигдах шаардлага, дүгнэх аргачлалыг нээлттэй танилцуулах,
- зохион бичлэг хийсэн байдалд анализ хийн, мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшинг тогтоож, дүгнэлт гаргах,
- гаргасан дүгнэлтэд үндэслэн багш цаашдын ажлаа төлөвлөж, арга зүйгээ тодорхойлно.

2. Сурагчдын **эх зохион бичих чадварыг** үнэлэх шалгуур, гүйцэтгэлийн түвшинг харуулах рубрик:

| Түвшин шалгуур   | ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН   |  |   |  |
|--|---|--|---|--|
|  | I   | II   | III   | IV   |
| Зорилгоо ойлгож, агуулга, сэдвийн холбоог гаргасан байдал (0-3 оноо) | Эх зохиохдоо: <ul style="list-style-type: none"> <li>зорилгоо тодорхойлж чадаагүй, сэдэвтэй холбоотой санааг салангид үг, хэллэг, цөөн тооны өгүүлбэрээр илэрхийлэхийг оролддог.</li> </ul>           | Эх зохиохдоо: <ul style="list-style-type: none"> <li>зорилгоо дундаж хангаж, бодол санаагаа илэрхийлэх логик холбоо үе үе алдагддаг.</li> </ul>  | Эх зохиохдоо: <ul style="list-style-type: none"> <li>зорилгоо харьцангуй гүйцэд хангаж, агуулга, сэдвийн холбоог ерөнхийд нь зөв гарган бичдэг.</li> </ul>  | Эх зохиохдоо: <ul style="list-style-type: none"> <li>зорилгоо ойлгож, агуулга, сэдвийн холбоог сайн гаргаж, санаагаа бүрэн гүйцэд илэрхийлдэг.</li> </ul>  |
| Үгийн сангийн нөөц, хэлзүйн найруулга (0-3 оноо)                     | <ul style="list-style-type: none"> <li>Бодол санаагаа илэрхийлэх логик холбоо олон тохиолдолд алдагдсан;</li> <li>үг, хэллэгийг оновчгүй сонгож, зөв бичгийн дүрмийн алдаа олныг гаргадаг.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Эмх цэгц муутай цөөн өгүүлбэрээр санаагаа илэрхийлдэг;</li> <li>үг, хэллэгийг хязгаарлагдмал хүрээнд ашигладаг: нэг хэвийн үг, хэллэгийг оновчгүй, олон дахин давтаж хэрэглэдэг.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Гол санаагаа логик дараалал сайтай ч дутуу илэрхийлдэг;</li> <li>агуулга, сэдэвтээ тохируулан үгийн сангийн нөөцөөс судалсан шинэ үг, хэллэгийн дийлэнхийг ашигладаг.</li> </ul> | <ul style="list-style-type: none"> <li>Бодол санаагаа эмх цэгцтэй, логик холбоотой, найруулга сайтай илэрхийлдэг;</li> <li>үгийн сангийн нөөцөө бүтээлчээр ашиглаж, агуулга, сэдэвтэйгээ бүрэн нийцүүлж, оновчтой зөв хэрэглэдэг.</li> </ul> |
| Зөв бичгийн дүрэм баримтлан бичсэн байдал (0-4 оноо)                 | өгүүлбэрийн тоо дутуу.  | Өгүүлбэрийн тоо дутуу, олон зөв бичгийн дүрмийн алдаа гаргадаг.  | өгүүлбэрийн тоо гүйцэд боловч хэд хэдэн зөв бичгийн дүрмийн алдаа гаргадаг.   | өгүүлбэрийн тоо гүйцэд боловч цөөн тооны зөв бичгийн дүрмийн алдаа гаргадаг.   |

3. Сурагчдын **ярих чадварыг** хичээлийн явцад ажиглан, суралцахуйн үр дүнгийн гүйцэтгэлийн түвшингээ ашиглан тэмдэглэл хөтөлж, сурагчийн орос хэлний үг, хэллэгийг зөв дуудах, судалсан сэдвийн хүрээнд харилцан ярилцах чадварт гарч байгаа өөрчлөлтийг оношлох, гаргаж буй алдааг хэрхэн залруулах талаар тэдэнд зөвлөгөө өгч ажиллах боломжтой.

**IX ангийн сонсох-ярих нэгжийн хүрээнд сурагчдын ярих чадварыг ажиглан тэмдэглэл хөтлөх жишээ**

**Суралцахуйн үр дүн:** Сурагч орос хэлний авиа, үгийн өргөлт, өгүүлбэрийн аялгыг ялган таньж, зөв дуудаж чаддаг болно.

**Суралцахуйн үр дүнгийн шалгуур:** Харилцагчийнхаа ярианы өнгө, аялгаас түүний бодол санааг ойлгож, хариу үйлдэл хийдэг: асуултад хариулдаг, ойлгоогүй зүйлээ тодруулан асуудаг, өөрийн бодол санааг илэрхийлдэг.

| Д/д | Сурагчийн нэр | Гүйцэтгэлийн түвшин |          |          |          |
|-----|---------------|---------------------|----------|----------|----------|
|     |               | I                   | II       | III      | IV       |
| 1   | Б. Ариунаа    |                     | ✓        |          |          |
| 2   | .....         |                     |          | ✓        |          |
| 3   | .....         |                     | ✓        |          |          |
| 19  | .....         | ✓                   |          |          |          |
| 20  | Г. Энхболд    |                     |          |          | ✓        |
|     | <b>Нийт</b>   | <b>4</b>            | <b>7</b> | <b>6</b> | <b>3</b> |

**Дүгнэлт:** Ангийн 20 сурагчийн 3 нь буюу нийт сурагчдын 15% нь IV түвшин буюу харилцагчийнхаа бодол санааг бүрэн ойлгож, ярилцагчийн асуултад харцулан, ойлгоогүй зүйлээ тодруулан асууж, өөрийн бодол санааг үндэслэлтэйгээр илэрхийлдэг, 30% нь буюу 6 сурагч III түвшин буюу харилцагчийнхаа бодол санааг бүрэн ойлгож, ярилцагчийн асуултад харцулан, ойлгоогүй зүйлээ тодруулан асуудаг боловч хааяа өөрийн бодол санааг үндэслэлтэйгээр илэрхийлэхэд бэрхшээлтэй байдаг. Харин нийт сурагчдын 55% нь I, II түвшин буюу ярилцагчийнхаа бодол санааг дутуу ойлгодог, асуусан асуултад нь энгийн өгүүлбэр эсвэл салангид үг хэллэгээр харцулахыг оролдож байна.

Цаашид хичээл дээр үг хэллэгийг даган дууриаж хэлэх, сургалтын бичлэг сонсох, харилцан яриа зохион дүрд тоглох дасгалуудыг үр дүнтэй зохион байгуулж, харилцан ярих чадварыг сайжруулахад анхаарах нь зүйтэй.

#### 4. Сурагчдын бие даалтын ажлын гүйцэтгэлийг нэгтгэн дүгнэх арга, аргачлал

Гадаад хэлний хичээлээр сурагчдын мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн үр дүнгийн үнэлгээг бие даалтын ажлын хэлбэрээр хийх нь үр дүнтэй болдог. Суурь боловсролын түвшинд сурагчдын унших-бичих чадварыг үнэлэхэд бие даалтын ажлын нэг хэлбэр болох Аман сэтгүүл (Устный журнал), БДБ-ын түвшинд Төсөлт ажил (Проектная работа)-г ашиглаж болно. Бие даалтын ажлыг сурагч ганцаараа болон бусадтай баг болон гүйцэтгэж болно. Бие даалтын ажил нь сурагчдын судалсан мэдлэг, чадварыг бататгах, сурах идэвхи оролдлогыг өрнүүлэх, тэдэнд бие даасан судалгаа явуулах чадвар (асуудал дэвшүүлэх, мэдээлэл цуглуулж боловсруулах, туршилт хийх, дүгнэлт гаргах)-ыг төлөвшүүлэх, бүтээлч чадвар болон логик сэтгэхүйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хичээлээр олсон мэдлэг, чадвараа нэгтгэн цэгцэлж, амьдралд хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх юм.

Бие даалтын ажлын сэдвийг багшийн санал болгосон сэдвүүдээс сонгох болон сурагч өөрөө багштай зөвлөлдөж сэдвийн санал оруулж болно. Бие даалтын ажил нь багшийн удирдлага дор явагдах тул багш болон сурагчдаас тодорхой хэмжээгээр судалгааны арга барил, их цаг зав шаардах учир сурагч жилд нэг удаа сонирхсон Модуль (XII ангид 3 модуль судалдаг) буюу бүлэг сэдвээр (IX ангид 4 бүлэг сэдэв судалдаг) уг ажлыг гүйцэтгэхээр зохион байгуулж болно. Багш бие даалтын ажил гүйцэтгэх сурагчдыг удирдамжаар бүрэн хангаснаар амжилтанд хүрнэ.

Бие даалтын ажлыг дараах шалгуураар үнэлж, үр дүнгийн үнэлгээнд тооцож болно. Бие даалтын ажлыг багш удирдан чиглүүлж, тэмдэглэл хөтөлнө.

Бие даалтын ажлыг дараах шалгуураар үнэлэхдээ гүйцэтгэлийн түвшин хоорондын ялгааг тодорхойлж, харгалзах оноог тодорхой болгоно.

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур  |   | ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН  |  |   |  |
|---|---|--|--|---|--|
|   |   | I  | II   | III   | IV   |
| Бие даалтын ажлын бэлтгэл шат   | Сэдэв сонгох, багаа бүрдүүлэх, ажлаа төлөвлөх, дотоод зохион байгуулалт хийж ажил хуваарилах (багаар ажиллах бол), сэдэвт тохирсон мэдээлэл, баримт, зураг цуглуулах, судалгаа хийх, багшаас зөвлөгөө авсан байдал. | Бусдын дэмжлэгтэйгээр сэдэв сонгон ү/аж-ны төлөвлөгөө гаргаж, сэдэвт тохирох мэдээлэл, баримт, зураг цуглуулж, судалгаа хийхийг оролдсон                 | Сонгосон сэдвийн дагуу багшийн дэмжлэгтэйгээр ү/аж-ны төлөвлөгөө гарган сэдэвт тохирох мэдээлэл, баримт, зураг цуглуулж, судалгаа хийсэн.  | Сонгосон сэдвийн дагуу ү/аж-ны төлөвлөгөө гарган сэдэвт тохирсон мэдээлэл, баримт, зураг цуглуулж, судалгаа хийхдээ багшаас зөвлөгөө авч байсан.  | Сэдвээ оновчтой сонгож, ү/аж-ны төлөвлөгөө гаргах, сэдэвт тохирсон мэдээлэл, баримт, зураг цуглуулж, судалгаа хийхдээ багшаас тухай бүр нь зөвлөгөө авч байсан.  |
|   | Бие даалтын ажлыг гүйцэтгэх үе шат  | БДА-ын ач холбогдол, бүтэц, зорилго, агуулга, сэдвийн холбоо, судалгаа, цуглуулсан баримт мэдээллийг ангилж, цэгцэлсэн, үр дүнг төлөвлөсөн байдал,       | БДА-ын бүтцэд тавигдах шаардлагын дагуу хийхийг хичээсэн, мэдээллийн ач холбогдлыг тодорхойлж чадаагүй, агуулга сэдвийн холбоо алдагдсан, бусдын дэмжлэгтэйгээр судалгаа хийхийг оролдсон. | БДА-ын бүтцэд тавигдах шаардлагын дагуу хийсэн, мэдээллийн ач холбогдлыг хангалтгүй тодорхойлсон, агуулга сэдвийн холбоо алдагдсан, судалгаа хийж, цуглуулсан баримт мэдээллийг бусдын дэмжлэгтэйгээр ангилж цэгцэлсэн ба үр дүнг төлөвлөсөн. | БДА-ын бүтцэд тавигдах шаардлагын дагуу хийсэн, мэдээллийн ач холбогдлыг тодорхойлсон, агуулга сэдвийн холбоог гаргаж, судалгаа хийж, цуглуулсан баримт мэдээллийг ангилж, цэгцэлсэн, үр дүнг төлөвлөж чадсан. |
| Бичсэн ажлын найруулга, үгийн сан, хэлзүйн мэдлэг, эх сурвалжийг бүтээлчээр ашигласан байдал, |   | Бусад эх сурвалжаас авсан мэдээллийг утгыг бүрэн ойлгоогүй шууд хуулбарласан,, хэлзүйн дүрмийн алдаа их гаргасан, үгийн сангийн нөөцөө буруу хэрэглэсэн. | Бусад эх сурвалжаас авсан мэдээллийг найруулан бичих чадвар дутмаг, хэлзүйн дүрмийн алдаа нилээд гаргасан, үгийн сангийн нөөц нь агуулга, сэдэвт зарим тохиолдолд тохироогүй.              | Мэдээллийг найруулга сайтай ч бага зэрэг зөв бичгийн дүрмийн алдаатай, үгийн сангийн нөөцөө агуулга, сэдэвтэйгээ нийцүүлэн зөв сонгон хэрэглэж чадсан, эх сурвалжийг ашигласан.   | Мэдээллийг найруулга сайтай, хэлзүйн дүрмийн алдаагүй, үгийн сангийн нөөцөө бүтээлчээр ашиглан, агуулга, сэдэвтэйгээ бүрэн нийцүүлж, оновчтой зөв хэрэглэсэн, эх сурвалжийг бүтээлчээр ашигласан.              |

|                                      |   |  |  |  |   |
|--------------------------------------|---|--|--|--|---|
| Бие даалтын ажилд тавигдах шаардлага | Оршил, гарчиг, дүгнэлт, ашигласан материалын жагсаалт, хавсралт, Бие даалтын ажилд сонгосон материалын чанар (зохиомж, зураг, бүдүүвч ашигласан байдал, хийсэн зүйлийн харагдах үзэмж) Ажлын үр дүнд дүгнэлт гаргаж шинжилгээ хийсэн байдал | БДА-д тавигдах шаардлага хангаагүй, бусдын дэмжлэгтэйгээр сэдэвт ажлын үр дүнд дүгнэлт хийхийг оролдсон.   | БДА-д тавигдах шаардлагыг дутуу хангасан, бусдын дэмжлэгтэйгээр сэдэвт ажлын үр дүнд дүгнэлт хийсэн.   | БДА-д тавигдах шаардлагыг зарим тохиолдолд дутуу хангасан, сэдэвт ажлын үр дүнд дүгнэлт гаргаж шинжилгээ хийсэн.   | БДА-д тавигдах шаардлагыг бүрэн хангасан, сэдэвт ажлын үр дүнд дүгнэлт гаргаж, нарийн шинжилгээ хийж чадсан.  |
| Бие даалтын ажлаа тайлагнах үе шат   | МХТ болон бусад сонирхолтой хэлбэрийг ашигласан, эмх цэгцтэй, ярианы өнгө аясыг зохистой гарган алдаагүй зөв ярьсан, шинэлэг бүтээлч санаа дэвшүүлсэн, бусдын сонирхсон асуултад хариулж чадаж буй байдал,                                  | МХТ ашиглан мэдээллийг илэрхийлэхийг оролдсон нь эмх цэгц муутай, нилээд алдаатай байсан ба бусдын сонирхсон асуултын дийлэнхэд нь хариулж чадаагүй.               | МХТ ашиглан мэдээллийн тал хувийг ярьсан, төрөл бүрийн эх сурвалжаас авсан мэдээллийг нэгтгэн дүгнэсэн ч, эмх цэгц муутай, нилээд алдаатай ярьсан, бусдын сонирхсон асуултын тал хувьд нь хариулт өгсөн. | МХТ ашиглан мэдээллийн дийлэнхийг логик дэс дараалалтай ярьсан, төрөл бүрийн эх сурвалжаас авсан мэдээллийг нэгтгэн дүгнэж, эмх цэгцтэй, бага зэрэг алдаатай ярьсан, шинэлэг санаа дэвшүүлсэн, бусдын сонирхсон асуултын дийлэнхэд хариулт өгч чадсан. | МХТ ашиглан мэдээллийг логик дэс дараалалтай ярьсан, төрөл бүрийн эх сурвалжаас авсан мэдээллийг нэгтгэн дүгнэж, бодол санаагаа илэрхийлсэн дүгнэлт гарган эмх цэгцтэй, алдаагүй зөв ярьсан, шинэлэг бүтээлч санаа дэвшүүлсэн, бусдын сонирхсон асуултад тодорхой хариулт өгч чадсан. |
| Бие даалтын ажлын үр дүнгийн үнэлгээ | - өөрийн үнэлгээ, - хамт олны үнэлгээ, - багшийн үнэлгээ (суралцагчдын хандлага, төлөвшлийн үнэлгээг давхар хийнэ)  | Өөртөө итгэлгүй өөрийн бүтээлийг үнэлэх чадвар дутмаг, бие даан сурах чадвар дутмаг, шинжлэн судлах хүсэл сонирхол дутмаг, бусадтай хамтран ажиллах чадвар дутмаг. | Өөрийн бүтээлийг үнэлэхдээ өөртөө итгэлгүй, бие даан сурах чадвар дутмаг, шинжлэн судлах хүсэл сонирхол дутмаг, бусадтай хамтран ажиллахыг хичээдэг.   | Өөрийн бүтээлийг үнэлэх чадвартай ч өөртөө эргэлздэг, бие даан сурах арга барил эзэмшсэн, шинжлэн судлах хүсэл сонирхолтой, бусадтай хамтран ажиллах чадвартай.  | Өөрийн бүтээлийг үнэлэх чадвартай, бие даан сурах арга барил эзэмшсэн, шинжлэн судлах хүсэл сонирхолтой, бусадтай хамтран ажиллах чадвартай.  |

Бие даалтын ажлыг гүйцэтгэснээр сурагч дараах чадваруудыг эзэмшинэ. Үүнд:

- асуудал дэвшүүлэх, зорилго, зорилтоо тодорхойлох,
- үйл ажиллагаагаа төлөвлөх,
- шаардлагатай мэдээллийг хайх, судалгаа хийх,
- хичээлээр олсон мэдлэг, чадвараа өөр нөхцөлд ашиглах,
- МХТ ашиглах,
- өөрийгөө болон бусдыг үнэлэх, дүн шинжилгээ хийх,
- ажлын үр дүнгээ тайлагнах.

## ДӨРӨВ. НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР, ОРЧУУЛГА

### 4.1. НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

**Диагностическое оценивание** (түвшин тогтоох / оношилох үнэлгээ) – это определение начального уровня сформированности знаний, умений и навыков (ЗУН) и компетентностей учащегося. Диагностическое оценивание обычно проводится в начале учебного года или на первом занятии изучения темы, учебного раздела, главы.

**Критерий** – это перечень различных видов деятельности, которую он осуществляет в ходе работы и должен в совершенстве освоить.

**Обратная связь** (эргэх холбоо) – непрерывное взаимодействие с обучающимися, в результате которого происходит корректирование и дальнейшее планирование процесса обучения.

**Ожидаемые / планируемые результаты** (хүлээгдэж буй үр дүн / суралцахуйн үр дүн) – усвоенные знания, умения, навыки; то, что обучающийся будет знать, понимать и уметь после успешного окончания процесса обучения.

**Продуктивные виды речевой деятельности** (ярианы үйл ажиллагааны бүтээмжтэй төрлүүд) – виды речевой деятельности, с помощью которых обеспечивается выражение мыслей в устной (говорение) и письменной (письмо) формах.

**Разноуровневые задания** (ялгаатай түвний даалгавар) – задания разного уровня сложности, которые используются для организации дифференцированного обучения с учётом способностей обучающихся.

**Рефлексия** (хичээлийн нэгдсэн дүгнэлт) – мыслительный процесс, направленный на самопознание, переосмысление и анализ собственных результатов деятельности.

**Рецептивные виды речевой деятельности** (ярианы үйл ажиллагааны хүлээн авах хэлбэрүүд) – виды речевой деятельности, связанные с восприятием речи – устной (слушание/аудирование) и письменной (чтение).

**Рубрика** – это перечень критериев оценивания учащихся. Определяется целями обучения и содержательно наполняется критериями, которые раскрывают данную рубрику.

**Стартовое оценивание** (гарааны үнэлгээ) – определение остаточных знаний и умений обучающихся относительно прошедшего учебного года.

**Суммативное оценивание** (үр дүнгийн үнэлгээ) – вид оценивания, который проводится по

завершении определенного учебного периода (четверть, полугодие, учебный год), а также изучения разделов в соответствии с учебной программой.

**Уровень учебных достижений** (гүйцэтгэлийн хүрэх түвшин) – степень развития учебных достижений обучающихся в соответствии с критериями оценивания.

**Формативное оценивание / текущая оценка** (албан бус үнэлгээ, явцын үнэлгээ) – вид оценивания, который проводится в ходе повседневной работы в классе, является текущим показателем успеваемости обучающихся, обеспечивает, обратную связь между учеником и учителем.

### 4.2. НЭР ТОМЬЁНЫ ОРЧУУЛГА

**Адаптированный текст** – хялбаршуулсан эх

**Аутентичный текст** – жинхэнэ буюу

хялбаршуулаагүй эх

**Диалог-расспрос** – асуулт хариулт бүхий

харилцан яриа

**Диалог-побуждение** – яриа өдөөх харилцан яриа

**Диалог-обмен мнениями** – санал солилцох

харилцан яриа

**Диалог-сообщение информации** – мэдээлэл өгөх

харилцан яриа

**Диалог этикетного характера** – хэл ярианы хэм

хэмжээ баримталсан харилцан яриа

**Критерии оценивания результатов обучения** –

суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур

**Образование устойчивого развития** – тогтвортой

хөгжлийн боловсрол

**Подход** – хандлага

**Поисковое / изучающее чтение** – судлаж / хайж

унших

**Просмотровое чтение** – гүйлгэж унших

**Различать** – ялган таних

**Реагировать (ответить)** – хариу үйлдэл хийх

(хариулах)

**Реплика (диалога)** – асуулт / хариулт

**Речевой этикет** – хэл ярианы хэм хэмжээ /

ярианы жаяг

**Сопоставить** – жиших (харьцуулах)

**Трансформация** – хувиргах, өөрчлөх, хөрвүүлэх

**Фраза (фонетическая единица)** – хэллэг, хэлц,

өгүүлбэр

**ЕБС-ийн Орос хэл хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:**

|              |  |
|--------------|--|
| Г.Нарангэрэл | Нийслэлийн лаборатори 20-р сургуулийн сургалтын менежер, зөвлөх багш |
| И.Мяндас     | Нийслэлийн 2-р сургуулийн багш, зөвлөх                               |

**Хөндлөнгийн шинжээч:**

|             |  |
|-------------|--|
| Б. Батчимэг | “Сакура” сургуулийн үндэсний сургагч багш, магистр |
|-------------|--|

**Техникийн редактор:**

|             |  |
|-------------|--|
| Д.Энхжаргал | Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн, магистр |
| Ш.Сувдмаа   | Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр       |

**Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:**

|           |                                      |
|-----------|--------------------------------------|
| С.Мөнхмаа | Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр |
|-----------|--------------------------------------|

**Цаасны хэмжээ:** А4

**Хэвлэлийн хуудас:** 5.5 х.х



*Дэлгэрэнгүй мэдээллийг:*

[www.eec.mn](http://www.eec.mn)



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,  
Утас/Факс: 976-11 7011- 8486  
И-майл: [info@eec.mn](mailto:info@eec.mn) Вэб: [www.eec.mn](http://www.eec.mn)